



НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас Нотариатын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2011 оны 02 дугаар сарын 11-ний өдөр баталж, 2011, 2013, 2015, 2018, 2019, 2020, 2021, 2022, 2024 онуудад тус тус нийт 9 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик хэрэгцээ, шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” хэсгийн 4.1.1.14-д “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хуулиас давсан зохицуулалт бүхий дүрэм, журмуудад дүн шинжилгээ хийж, цэгцлэх арга хэмжээ авна.” гэж,

Монгол Улсын Их Хурлын 2025 оны “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолын 2 дахь заалтын 4-д “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх.” гэж,

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 54-д “Нотариатын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор зайн гэрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох” гэж,

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 206 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1.1-д “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуульд нийцээгүй, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, авлига, ашиг сонирхлын зөрчил гарах нөхцөл бүрдүүлсэн, зөвшөөрлийн шинжтэй зохицуулалт агуулсан болон холбогдох хууль тогтоомж

шинэчлэн батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл хүчингүй болсонтой холбогдуулан дагаж мөрдөхгүй болсон захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгож, хууль тогтоомжид нийцүүлэх” гэж тус тус заасан.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Нотариатын тухай хуульд нотариатын зөвшөөрөл олгох эрх бүхий Мэргэшлийн хорооны ажиллах журам, мэргэшлийн болон тойрог шилжих шалгалт авах журам, нотариатын үйлчилгээний хөлс, зардлыг тогтоох журам, нотариатын үйлдэл хийх заавар, Сахилгын зөвлөлийн ажиллах журам, хуралдааны дэг, шийдвэр гаргах үйл ажиллагаа зэрэг нотариатчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах болон хууль зүйн баталгааг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг хуулиар бус журмаар зохицуулахаар холбогдох этгээдэд хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтуудыг тусгасан байна.

Нотариатын тухай хуульд журам, заавар батлах эрх олгосон нийт 10 заалт байгаа нь хууль тогтоомжийн нэгдсэн бодлого алдагдах, хуулийг анх батлах үед тогтоосон үзэл баримтлал өөрчлөгдөх, журам батлахдаа хуулиар тогтоогоогүй нэмэлт шалгуур, шаардлага тогтоох, нийтийн ашиг сонирхлоос илүү тодорхой этгээд, бүлгийн ашиг сонирхолд нийцүүлэн дүрэм, журмыг өөрчлөх, улмаар хүний эрх, эрх чөлөөнд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна.

Иймд хууль тогтоомжийн тодорхой, ойлгомжтой, холбогдох харилцааг бүрэн зохицуулсан байх, нэг мөр хэрэгжих зарчмыг хангах үүднээс одоогоор журмаар зохицуулж байгаа суурь шинжтэй харилцааг хуульд тусгах практик шаардлагыг харгалзан Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

Мөн түүнчлэн 2025 онд Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ¹ хийсэн бөгөөд үнэлгээний тайланд дараах асуудлыг боловсронгуй болгох талаар зөвлөмжид дурдсан. Тухайлбал:

1.Зайн гэрчлэлтийн зохицуулалтийн талаар:

Нотариатын тухай хуулийн 4.3-т “Нотариатч нь төрийн нэрийн өмнөөс хөндлөнгийн гэрчийн үүрэг гүйцэтгэж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцаанд оролцож байгаа этгээдэд эрх зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасан бөгөөд энэхүү чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний цахим шилжилтийг дэмжих, иргэд, хуулийн этгээдэд түргэн шуурхай, чирэлдэл багатай үйлчилгээ үзүүлэх зорилгоор нотариатын үйл ажиллагааг үе шаттайгаар зайн гэрчлэлтийн зохицуулалтыг бий болгох шаардлага тулгарч байна.

Нотариатын Танхим 2024, 2025 онд дараах төрлийн нотариатийн үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд үзүүлсэн байна:

Д/д	Нотариатын үйлдлийн төрөл	2024 он	2025 он
1	Гэрээ, хэлцэл	618,277	563,036
2	Итгэмжлэл	308,957	295,343
3	Гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэх	116,272	110,965
4	Өвлөх эрхийн гэрчилгээ	25,048	27,714
5	Тэмдэглэл	5057	7014
7	Мэдэгдэх хуудас	153	362

¹ Монголын Нотариатчдын танхим. Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. 2025 он.

Нийт	1,073,764	1,004,434
------	-----------	-----------

Дээрх тоон үзүүлэлтээс харахад иргэдийн хамгийн түгээмэл авдаг 3 төрлийн нотариатын үйлчилгээ болох гэрээ, хэлцэл гэрчлэх, итгэмжлэл гэрчлэх, гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэх үйлдлийг зайнаас гэрчлэх хэлбэрээр гүйцэтгэх боломжтой бөгөөд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн нөхцөл бүрэн бүрдсэн байна.

Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээнд цахимаар болон зайнаас гэрчлэх үйлчилгээний ялгаа, хамрах хүрээг тодорхойлох, мөн зайнаас гэрчлэх үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардагдах дэд бүтэц, мэдээллийн технологийн шийдэл, хүний нөөцийн чадавхыг харгалзан судалсан.

Сонгон судалсан гадаадын зарим улсын зайн гэрчлэлтийн үйлчилгээг нэвтрүүлсэн туршлагаас үзэхэд Франц, Герман, Эстони, Сингапур Улс нь иргэний танин баталгаажуулалтын сүүлийн үеийн найдвартай систем, орчин үеийн технологийн шийдэл, өндөр хурдны интернэтийн дэд бүтцийг ашиглахын зэрэгцээ төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог хангах замаар зайн нотариатын үйлчилгээг нэвтрүүлсэн байна.

Монгол Улсын хувьд нотариатын зайн гэрчлэлтийг нэвтрүүлэх нийгмийн зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн бөгөөд эрх зүйн зохицуулалтуудыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Зайн гэрчлэлтийг нэвтрүүлснээр Монгол Улсын Иргэний хуульд заасан цахим хэлбэрээр хэлцэл байгуулах зохицуулалтыг бодитоор хэрэгжүүлэх, иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх, нотариатчдын орлого тэнцвэржих, тойрог шилжих хүсэлт буурах боломжтой юм.

2.Нотариатын үйлчилгээний хөлс, зардлыг тогтоох зохицуулалтыг шинэчлэх, боловсронгуй болгох тухай:

Нотариатын үйлчилгээний хөлс, зардлыг тогтоох тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд хөлс, зардлын хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бус хараат бус, хөндлөнгийн, орон тооны бус Хяналтын зөвлөл эдийн засгийн нөхцөл байдал, үйлчилгээний өртөг, зах зээлийн орчны өөрчлөлттэй уялдуулан тогтоодог байх зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Түүнчлэн нийгмийн халамжтай холбоотой итгэмжлэлийг гэрчлэхэд нотариатын үйлчилгээний хөлснөөс чөлөөлөх зохицуулалт оруулах, нотариатчийн туслахын эрх зүйн байдлыг тодорхойлох зэрэг асуудлыг хуулийн төсөлд тусгана.

Гадаадын зарим улсын нотариатын үйлчилгээний хөлс тогтоох аргачлалыг авч үзвэл тухайн улсын эрх зүйн тогтолцооноос хамааран ялгаатай байдлаар хөгжсөн байдаг. Монгол Улс нь эх газрын буюу Латин нотариатын системд (Франц, Герман загвар) хамаарах тул Европын орнуудын туршлага манай улсын зохицуулалттай илүү нийцдэг байна.

3.Нотариатын тухай хуулиар нотариатын зөвшөөрөл олгох зохицуулалтыг боловсронгуй болгох талаар:

Нотариатын тухай хуулиар нотариатын зөвшөөрөл олгох журам, Мэргэшлийн хорооны ажиллах журам, мэргэшлийн болон тойрог шилжих шалгалт зохион байгуулах журам, нотариатын үйлдэл хийх заавар, Сахилгын зөвлөлийн ажиллах журам, хуралдааны дэг, шийдвэр гаргах ажиллагаа зэрэг нотариатчийн эрх зүйн байдлыг тодорхойлох суурь харилцааг журмаар зохицуулахаар холбогдох этгээдэд хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтууд үйлчилж ирсэн.

Гэвч дээрх харилцаа нь нотариатын үйл ажиллагааны үндсэн зохицуулалтад хамаарах тул хууль тогтоомжийн тодорхой, тогтвортой, нэг мөр хэрэгжих зарчмыг хангах үүднээс журам, заавраар зохицуулж байгаа суурь шинжтэй зохицуулалтыг хуулийн түвшинд нарийвчлан тусгах шаардлага үүсээд байна. Ингэснээр нотариатын үйл ажиллагааны эрх зүйн орчны тогтвортой байдал хангагдаж, иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрх зүйн баталгааг сайжруулах нөхцөл бүрдэх юм.

4. Нотариатын тойрог, тойрог шилжих зохицуулалтын талаар

Нотариатын тухай хуулийн 2025 онд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд нотариатын тойргийг нэмэх, өөрчлөх санал гаргах эрхийг Нотариатын танхимд хуулиар олгосон талаар дурдсан байна. Гэвч батлагдсан зарим тойрог, ялангуяа алслагдсан орон нутагт нотариатын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилго бодитоор хэрэгжихэд нотариатч үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжин ажиллах боломж хангалтгүй байгаа нь нотариатч тойрог шилжих хүсэлт гаргах нэг үндэслэл болж байна.

Нотариатч тойрог шилжин ажиллах хүсэлтээ өгч мэргэшлийн шалгалт дахин өгөх зохицуулалтыг хуульчилснаар тойрог шилжих шалгалтыг 1 удаа зохион байгуулсан байна. Судалгааны явцад тойрог шилжих шалгалт өгч нөөцөд орсон нотариатчдаас сул орон тоо гарсан тойрогт томилгоо хийлгүй, үндсэн нөөцөөс томилгоо хийдэг гэсэн шүүмжлэл гарсан байна. Нөгөө талаас нотариатын үйл ажиллагааны орлогоор амьжиргаагаа залгуулах боломж хязгаарлагдмал болон бусад шалтгааны улмаас тухайн тойрогтоо ажиллах боломжгүй болсон нотариатчдад мэргэшлийн ур чадвараараа өрсөлдөн өөр тойрогт шилжин ажиллах боломжийг бүрдүүлсэн нь эерэг зохицуулалт болсон байна. Гэвч одоогийн тойрог шилжих шалгалтын агуулга нь нотариатчийн мэргэшсэн байдлыг бодитой үнэлэх, хэмжигдэхүйц шалгуур тогтоох түвшинд боловсруулагдаагүй байна.

Түүнчлэн нотариатч тойрог шилжих шалгалтыг дахин өгсөн боловч шалгалтын босго даваагүй тохиолдолд тухайн нотариатч өмнө ажиллаж байсан тойрогтоо үргэлжлүүлэн ажиллах нөхцөл бүрдэх боловч орлогын хүрэлцээ муу байх хүндрэл хэвээр үлдэж байна. Иймд нотариатын үйлчилгээг тойрог харгалзахгүйгээр үзүүлэх боломжтой зайны гэрчлэлтийн зохицуулалтыг энэхүү харилцаатай уялдуулан тусгах шаардлага бий болж байна.

5. Сахилгын зөвлөл болон Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн, эрх хэмжээ, бүрэн эрхийн хугацааны талаарх зохицуулалтын талаар

Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын тайланд² Нотариатын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа, үндсэн ажил эрхлэлт, гишүүнд тавигдах шаардлагын талаар судалсан байна.

Сахилгын зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг Нотариатын тухай хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд дөрвөн жил байхаар тусгах санал гарч байсан боловч Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад дэмжигдээгүй бөгөөд бүрэн эрхийн хугацааг тодорхой зохицуулалгүй орхигдуулсны улмаас 2019 онд байгуулагдсан Сахилгын зөвлөл бүрэлдэхүүний хувьд шинэчлэгдэх боломжгүйгээр ажиллаж байна.

Нөгөө талаас Сахилгын зөвлөлийг шүүх болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл тус бүр хоёр, Нотариатын

² Монголын Нотариатчдын танхим. Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. 2025 он.

танхимаас гурван гишүүн оролцсон нийт долоон гишүүнтэй холимог бүрэлдэхүүнтэй байгуулахаар хуульчилсан нь өмнө хийгдсэн хуулийн хэрэгжилтийн судалгаанд дурдсан асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлсэн зохицуулалт болсон байна.

Иймд Мэргэшлийн хороо болон Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, шийдвэр гаргах ажиллагааны үндсэн зохицуулалтыг хуулийн түвшинд илүү тодорхой тусгах шаардлагатай байна.

6.Нотариатын мэдэгдэх хуудасны үр нөлөөг дээшлүүлэх талаарх зохицуулалт:

Нотариатын мэдэгдэх хуудас нь нотариатын үйлдлийн нэг төрөлд хамаарах бөгөөд тухайн үйлчилгээний хууль зүйн үр дагавар, ач холбогдлыг иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээний хүрээнд хангалттай таниулах, практикт өргөн ашиглах ажил хангалтгүй байсныг сүүлийн жилүүдийн статистик үзүүлэлтээс дүгнэж болно. Тухайлбал, нотариатын мэдэгдэх хуудас бичсэн тоо 2021 онд 32, 2022 онд 72, 2023 онд 213, 2024 онд 155 бүртгэгдсэн байна.

Монголын Хуульчдын холбооны Нотариатчдын хөгжлийг дэмжих хорооноос санаачлан холбогдох байгууллагуудтай хамтран 2023 онд “Нотариатын мэдэгдэх хуудас шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл болох нь” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, Монголын Нотариатчдын танхим, шүүхийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандсан санал, зөвлөмжийг боловсруулсан байна. Үүний үр дүнд нотариатын мэдэгдэх хуудас бичсэн тоо өмнөх онтой харьцуулахад мэдэгдэхүйц өссөн нь тус үйлчилгээ нь шүүхийн ачааллыг бууруулах, маргааныг шүүхээс өмнөх шатанд шийдвэрлэхэд ач холбогдолтой болохыг харуулж байна.

Цаашид нотариатын мэдэгдэх хуудасны хэрэглээ, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор талууд үл маргах журмаар төлбөрийг төлөхөөр харилцан тохиролцож байгуулсан нотариатаар гэрчлэгдсэн бүх төрлийн гэрээ байхаар тусгах, мөн төлбөр төлөгчид гардуулсанд тооцох талаарх зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Энэ зохицуулалт бий болсноор нотариатын мэдэгдэх хуудасны хэрэглээ нэмэгдэж, шүүхийн өмнөх шатанд эрх зүйн маргааныг шийдвэрлэх боломж өргөжин, иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах механизм улам боловсронгуй болох боломж бүрдэх юм.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төслөөр нотариатын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нотариатын үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний цахим шилжилтийг дэмжих, нотариатын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны ил тод, тогтвортой байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлнэ.

Хуулийн төсөлд дараах үндсэн асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

- 1.нотариатын зайн гэрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- 2.нотариатын үйлчилгээний хөлс, зардлын хэмжээг тогтоох эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хуулийн түвшинд тогтоох;
- 3.нотариатын мэдэгдэх хуудасны эрх зүйн ач холбогдол, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай зохицуулалтыг тусгах;

4.нотариатын зөвшөөрөл олгох, Мэргэшлийн хорооны ажиллах журам, мэргэшлийн болон тойрог шилжих шалгалт зохион байгуулах журам, нотариатын үйлдэл хийх заавар, Сахилгын зөвлөлийн ажиллах журам, хуралдааны дэг, шийдвэр гаргах ажиллагаа зэрэг нотариатчийн эрх зүйн байдлыг тодорхойлох суурь харилцааг журмаар бус хуулийн түвшинд зохицуулах.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар нотариатын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт боловсронгуй болж, нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

1.Төрийн гэрчлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй нотариатын үйлчилгээ иргэн, хуулийн этгээдэд илүү ойртож, үйлчилгээний хүртээмж, шуурхай байдал, чирэгдэлгүй байдал нэмэгдэнэ.

2.Иргэний хуульд заасан цахим хэлбэрээр хэлцэл байгуулах эрх зүйн зохицуулалтыг бодитоор хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

3.Нотариатч тойргийн хязгаарлалтаас үл хамааран тодорхой төрлийн үйлчилгээг зайнаас үзүүлэх боломж бүрдэж, нотариатын үйлчилгээний тогтвортой байдал болон нотариатчийн үйл ажиллагааны санхүүгийн чадавх сайжирна.

4.Нотариатын мэдэгдэх хуудасны хэрэглээ, эрх зүйн ач холбогдол нэмэгдэж, маргааныг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэх боломж өргөжинө.

5.Нотариатын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны ил тод байдал, сахилга, хариуцлага дээшилнэ.

6.Албан тушаалтны эрх хэмжээнээс хэтэрсэн журам, заавраар зохицуулалт тогтоох нөхцөл хязгаарлагдаж, хууль тогтоомжийн тогтвортой, нэг мөр хэрэгжилт хангагдана.

7.Төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоо сайжирч, иргэн, хуулийн этгээдэд учрах хүндрэл, зардал буурна.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль нэмэлт болон хууль хоорондын уялдааг хангах зорилгоор шаардлагатай бусад хуулийн төслүүдийг боловсруулна.

----oOo----